ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2025/070НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2025 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Бадрал<br>Утас:70432545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.03 № 2/16

танай ______________-ны №______________-т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ш.ГАНБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сумын Засаг даргын тамгын газрын албан хаагчдад Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулалд 46.8 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 124.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр, тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэлээр 98.9 хувиар гүйцэтгэсэн гэж тайлагнасан ч сумын Засаг дарга дүгнээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Булган суманд 2024 онд өвөл хүндэрч гамшгийн байдал үүссэн, малын гоц халдварт өвчин гарсан, эрэн хайх үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, Засаг даргын тамгын газраас 19.5 сая төгрөгийн санхүүжилт олгож зарцуулсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,065,521.40** | **52,276,626** |
| **33** | **АВЛАГА** | 3,268,405.40 | 7,310,310 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 58,975.40 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 3,209,430 | 7,310,310 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 37,797,116 | 44,966,316 |
| **354** | **Хангамжийн материал** | 21,443,116 | 29,932,316 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,537,300 | 1,048,500 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,665,816 | 28,543,816 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 240,000 | 340,000 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,000,000 | - |
| 35600 | Мал амьтад | 16,354,000 | 15,034,000 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,016,438,886.54** | **7,847,842,461.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,016,438,886.54 | 7,847,842,461.83 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,791,362,686.54 | 7,622,766,261.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,492,204,330 | 5,830,318,418 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (520,225,662.72) | (640,156,389.80) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 589,137,440 | 668,067,440 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (403,008,690) | (388,939,439.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 281,374,4820 | 258,008,410 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (210,840,482.12) | (184,678,910.64) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 90,299,260 | 105,204,710 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (62,215,100.16) | (60,340,458.88) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 50,859,800 | 50,859,800 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (32,453,258.26) | (37,359,799.54) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,896,288,942.00 | 3,593,204,587.69 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,390,058,374.20) | (1,581,422,105.24) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 10,000,000 | 10,000,000 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 225,076,200 | 225,076,200 |
| 39301 | Программ хангамж | 1,965,000 | 1,965,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,965,000) | (1,965,000) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 225,076,200 | 225,076,200 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,057,504,407.94** | **7,900,119,087.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,691,071.30** | **2,808,197.69** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,691,071.30 | 2,808,197.69 |
| **413** | **Өглөг** | 1,691,071.30 | 2,808,197.69 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,673,731.20 | 2,808,197.69 |
| **4136** | **Бусад өглөг** | 17,340.10 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 17,340.10 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,055,813,336.64** | **7,897,310,890.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,055,813,336.64 | 7,897,310,890.14 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,297,577,669.00 | 1,297,577,669 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 1,297,577,669 | 1,297,577,669 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,411,346,713.81 | 6,265,773,065.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,411,346,713.81 | 1,424,275,512.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 4,841,497,553.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 346,888,953.83 | 333,960,155.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,057,504,407.94** | **7,900,119,087.83** |

**2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН** (төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,788,779,091** | **6,728,918,116.89** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **809,644,200** | **5,408,898,330.29** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 809,644,200 | 5,408,898,330.29 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 809,644,200 | 5,408,898,330.29 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 809,644,200 | 5,408,898,330.29 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **979,134,891** | **1,320,019,786.60** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 246,982,791 | 73,186,386.60 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 43,070,000 | 7,270,300 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,780,000 | 33,485,078.60 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 183,402,091 | 32,431,008 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 732,152,100 | 1,246,833,400 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 732,152,100 | 1,246,833,400 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,322,655,491.92** | **1,883,349,180.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,322,655,491.92** | **1,883,349,180.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,293,978,330.49 | 1,756,411,708.56 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 492,124,851.29 | 756,203,215.22 |
| 210101 | Үндсэн цалин | 308,099,625.48 | 389,937,705.83 |
| 210102 | Нэмэгдэл | 129,052,779.59 | 278,746,296.88 |
| 210104 | Урамшуулал | 25,020,102.67 | 39,361,470 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 29,952,343.55 | 48,157,742.51 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,522,184.48 | 92,565,057.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,013,552.50 | 64,323,685.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,921,248.66 | 7,567,492.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,936,999 | 3,894,626.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 877,307.68 | 3,319,187 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,773,076.64 | 13,460,066.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,903,380.53 | 147,257,502.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,551,036.53 | 17,951,873.74 |
| 210302 | Түлш, халаалт | 36,352,344 | 121,488,285 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 7,817,344 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,894,905.71 | 94,340,768.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 9,735,550 | 6,309,065.20 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,527,310 | 85,458,253.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,632,045.71 | 2,573,450 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,138,150 | 1,861,500 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,138,150 | 1,861,500 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,478,700 | 2,250,700 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 317,200 |
| 210604 | Урсгал засвар | 14,478,700 | 1,933,500 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,255,100 | 16,236,100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,255,100 | 16,236,100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,563,459.70 | 66,752,493 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,988,809.70 | 64,318,438 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 574,650 | 519,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 290,955 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 140,600 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,071,000 |
| 210807 | Газрын төлбөр | - | 412,500 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 607,097,598.78 | 578,944,371.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 220,562,283 | 121,824,000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,536,500 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 386,535,315.78 | 455,583,871.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,677,161.43 | 126,937,471.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,119,335 | 48,862,414.50 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 46,750,114.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,593,635 | 2,112,300 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,557,826.43 | 78,075,057.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,557,826.43 | 78,075,057.21 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **466,123,599.08** | **4,845,568,936.62** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 4,071,383.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 4,071,383.12 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (4,071,383.12) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **466,123,599.08** | **4,841,497,553.50** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (ТӨГРӨГӨӨР)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,003,175,511** | **1,323,229,216.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **3,209,430** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 3,209,430 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 3,209,430 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 3,209,430 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,003,175,511** | **1,320,019,786.60** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 271,023,411 | 73,186,386.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 43,070,000 | 7,270,300 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,780,000 | 33,485,078.60 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 207,442,711 | 32,431,008 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,730,700 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 732,152,100 | 1,246,833,400 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 732,152,100 | 1,246,833,400 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,003,175,511** | **1,323,229,216.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,003,175,511** | **1,323,229,216.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **968,270,054.57** | **1,188,981,234.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 491,342,339.01 | 743,491,626.29 |
| 210101 | Үндсэн цалин | 304,651,267.22 | 379,168,495.10 |
| 210102 | Нэмэгдэл | 128,689,152.28 | 272,776,190.06 |
| 210104 | Урамшуулал | 24,266,602.67 | 30,788,540 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,735,316.84 | 60,758,401.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,492,253.62 | 104,083,204.16 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,674,840.49 | 73,617,919.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,947,701.49 | 7,952,068.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,958,241.25 | 3,894,484.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 969,358.58 | 3,798,790.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,942,111.81 | 14,819,941.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,791,044.01 | 147,257,502.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,438,700.01 | 17,951,873.74 |
| 210302 | Түлш, халаалт | 36,352,344 | 121,488,285.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 7,817,344.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,353,550 | 55,138,518.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,266,400 | 3,563,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,873,750 | 49,002,068.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,213,400 | 2,573,450 |
| **2105** | **Нормативт зардал** | 941,200 | 1,028,700 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 941,200 | 1,028,700 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,214,400 | 2,250,800 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 280,600 | 317,000 |
| 210604 | Урсгал засвар | 1,933,800 | 1,933,800 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,255,100 | 16,236,100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,255,100 | 16,236,100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,834,100 | 66,841,903.10 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,386,600 | 64,407,848.10 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 270,000 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 519,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 255,000 | 290,955 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 30,000 | 140,600 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 892,500 | 1,071,000 |
| 210807 | Газрын төлбөр | - | 412,500 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 294,046,067.93 | 52,652,880 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 293,176,067.93 | 51,126,480 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 870,000.00 | 1,526,400 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,905,456.43** | **134,247,981.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,138,200 | 48,862,614.50 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,525,700 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 46,750,114.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,612,500 | 2,112,500 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,767,256.43 | 85,385,367.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,767,256.43 | 85,385,367.21 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (ТӨГРӨГӨӨР)

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,297,577,669.00 | 346,888,953.83 | 934,048,314.73 | 2,578,514,937.56 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,297,577,669.00** | **346,888,953.83** | **934,048,314.73** | 2,578,514,937.56 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 466,123,599.08 | 466,123,599.08 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,297,577,669.00** | **346,888,953.83** | **1,411,346,713.81** | 3,055,813,336.64 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,297,577,669.00** | **346,888,953.83** | **1,411,346,713.81** | 3,055,813,336.64 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 12,928,798.33 | 12,928,798.33 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,297,577,669.00** | **346,888,953.83** | **1,424,275,512.14** | 3,068,742,134.97 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | -12,928,798.33 | - | -12,928,798.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,841,497,553.50 | 4,841,497,553.50 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,297,577,669.00** | **333,960,155.50** | **6,265,773,065.64** | 7,897,310,890.14 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **(ТӨГРӨГӨӨР)**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | хэмнэлт хэтрэлт | хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,246,833,400 | 1,168,758,342.79 | 78,075,057.21 | 93.74 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,246,833,400 | 1,168,758,342.79 | 78,075,057.21 | 93.74 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,197,718,900 | 1,119,992,628.29 | 77,726,271.71 | 93.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 804,726,800 | 743,491,626.29 | 61,235,173.71 | 92.39 |
| 210101 | Үндсэн цалин | 449,743,500 | 379,168,495.10 | 70,575,004.90 | 84.31 |
| 210102 | Нэмэгдэл | 296,809,200 | 272,776,190.06 | 24,033,009.94 | 91.90 |
| 210104 | Урамшуулал | 18,574,100 | 30,788,540 | (12,214,440) | 165.76 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 39,600,000 | 60,758,401.13 | (21,158,401.13) | 153.43 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 100,765,800 | 104,083,204.16 | (3,317,404.16) | 103.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,520,800 | 73,617,919.47 | (5,097,119.47) | 107.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,061,300 | 7,952,068.98 | 109,231.02 | 98.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,030,600 | 3,894,484.49 | 136,115.51 | 96.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,030,600 | 3,798,790.13 | 231,809.87 | 94.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,122,500 | 14,819,941.09 | 1,302,558.91 | 91.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 166,103,200 | 147,257,502.74 | 18,845,697.26 | 88.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,837,900 | 17,951,873.74 | (6,113,973.74) | 151.65 |
| 210302 | Түлш, халаалт | 149,765,300 | 121,488,285 | 28,277,015 | 81.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,500,000 | 7,817,344 | (3,317,344) | 173.72 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,431,600 | 33,386,250 | 1,045,350 | 96.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,563,000 | 3,563,000 | - | 100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,249,800 | 27,249,800 | - | 100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,618,800 | 2,573,450 | 1,045,350 | 71.11 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,028,700 | 1,028,700 | - | 100 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,028,700 | 1,028,700 | - | 100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,250,800 | 2,347,700 | (96,900) | 104.31 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 317,000 | 413,900 | (96,900) | 130.57 |
| 210604 | Урсгал засвар | 1,933,800 | 1,933,800 | - | 100 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,308,400 | 14,308,400 | - | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,308,400 | 14,308,400 | - | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,736,500 | 36,722,145.10 | 14,354.90 | 99.96 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,302,000 | 34,288,090.10 | 13,909.90 | 99.96 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 519,000 | 519,000 | - | 100 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 330,000 | 290,955 | 39,0450 | 88.17 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 102,000 | 140,600 | (38,600) | 137.84 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,071,000 | 1,071,000 | - | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 412,500 | 412,500 | - | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,367,100 | 37,367,100 | - | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,840,700 | 35,840,700 | - | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,526,400 | 1,526,400 | - | 100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 49,114,500 | 48,765,714.50 | 348,785.50 | 99.29 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 49,114,500 | 48,765,714.50 | 348,785.50 | 99.29 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,002,000 | 46,750,114.50 | 251,885.50 | 99.46 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,112,500 | 2,015,600 | 96,900 | 95.41 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,248,233,400 | 1,168,758,342.79 | 78,075,057.21 | 93.63 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,246,833,400 | 1,168,758,342.79 | 78,075,057.21 | 93.74 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,246,833,400 | 1,168,758,342.79 | 78,075,057.21 | 93.74 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,400,000 | - | 1,400,000 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000 | - | 1,400,000 | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | | 100 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 25 | 25 | - | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 | - | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13 | 13 | - | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | - | 100 |

## ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 798,781.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 797,381.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Аймгийн Ахмадын хороо, Шинэ Ховд төслөөс үнэ төлбөргүй нийлүүлсэн ХАА-н зориулалттай тоног төхөөрөмжийг аймгийн ИТХ-аас данс бүртгэлд тусгах шийдвэр гаргаагүй хөрөнгийг бүртгэсэн, Баян судал багийн конторын барилгыг данс бүртгэлээс хасаагүй нийт 395,196.6 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Үнэ төлбөргүй ирсэн 210.0 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг орлогоор данс бүртгэлд тусгаагүй,
- Тайлант үеийн үр дүнг 390,941.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 11,033.0 мянган төгрөгөөр бууруулах бичилтийг орхигдуулсан,

Залруулагдаагүй нийт 15,735.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 1,400.0 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрснээс, 1,400.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.1.1. Орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* *Сумын ЗДТГ-ын төсөвт туслах үйл ажиллагааны орлогоос 1,400.0 мянган төгрөгийг бүрдүүлэн зарцуулахаар батлагдаж тайлант онд нэг ч төгрөгийн орлого бүрдүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:* *Төсвийг бодитой төлөвлөх, орлогыг бүрдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах*

#### 5.1.2 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* *Аймгийн ЗДТГ-аас 2024 оны 3 дугаар сард 1000 ширхэг пресс өвсийг хүлээн авсан эсэх нь тодорхойгүй, хөнгөлөлттэй үнээр олгосон өвс, пресс, тэжээлийн үнийг 100160051410 тоот дансанд төвлөрүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:" 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны 65 дугаар тогтоолоор "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын заалттай нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:* *Үнэ төлбөргүйгээр ирсэн өвс тэжээлийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх, өвс тэжээлийн үнийг аймгийн ЗДТГ-ын дансанд төвлөрүүлэх*

#### 5.1.3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* *Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр олгогдож газар эзэмшүүлэх гэрээ хийгдсэн ч газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1..3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д ‘Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах*

### 5.1.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u> Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээ, дараа жилийн төсвийн төсөл, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр., 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл / мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Булган сумын ЗДТГазар | 3 | 797,381.0 | 1 | 17,543.0 | 2 | 779,838.0 | 3 | 797,381.0 | - | - |
| Дүн | 3 | 797,381 | 1 | 17,543.0 | 2 | 779,838.0 | 3 | 797,381.0 | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл / мян.төгрөг/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Булган сумын Засаг даргын тамгын газар | 4 | 1,400.0 | | | | | 4 | 1400 | - | - | - | - |
| Дүн | 4 | 1,400.0 | - | - | - | - | 4 | 1400 | - | - | - | - |

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | - | 1 | - | - | 1 | - | - | - |
| НИЙТ | | | 1 | - | - | 1 | - | - | - |